


Эрүүгийн эрх зүй

ЦАХИМ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНД
ТУЛГАМДАЖ БҮЙ ЗАРИМ АСУУДАЛ

LEGAL REGULATION OF CYBERCRIME AND SOME OF THE ISSUES
PRESSING IT.



Л.Хаш

*Санхүү эдийн засгийн их сургуулийн, Эрх зүйн тэнхимийн
ахлах багш, хуульч, өмгөөлөгч, доктор (Ph.D).*



Б.Мөнгөннахиа

*Санхүү эдийн засгийн их сургуулийн, Эрх зүйн тэнхимийн
ахлах багш, хуульч, өмгөөлөгч, хууль зүйн магистр.*

Товч агуулга: Өнөөгийн техник технологи эрчимтэй хөгжин буй энэ цаг үед хүний өдөр тутмын амьдрал, аж ахуйн, байгууллагын үйл ажиллагаанд томоохон нөлөө үзүүлж байгаа интэрнет орчин буюу цахим орчин нь хүн төрөлхтний амьдралын салшгүй нэг хэсэг болоод байна. Тиймээс энэхүү судалгаагаар, цахим гэмт халдлагын эрх зүйн орчныг судлах, цахим гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, практикт нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлон, хохирогчийн эрх зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн санал, зөвлөмж боловсруулна.

Abstract: In this era of rapid development of technology, the internet or electronic environment has become an integral part of human life, which has a great impact on daily life, business, and organizational activities. Therefore, in this study, we will study the legal environment of cybercrime prevention and practice, and develop suggestions and recommendations aimed at solving the legal issues of victims.

Түлхүүр үг: цахим гэмт халдлага, цахим халдлага, урьдчилан сэргийлэх

Key word: Cybercrime attacks, cyberattacks, prevention of cybercrime

Оршил:

Саяхан л гар утас гэж юу вэ? Утсаар холбогдоогүй хэрнээ бусдыг ойртуулж хүмүүсийг хооронд холбох хэрэгсэл болж байгаа нь өөрөө гайхамшиг юм гэх зэрэг гайхан шагшин байсан үе маань ердөө 20 хан жилийн өмнө монгол улсад үүрэн телефон, интернэт орчин орж ирж байсан мөн технологийн дэвшил хөгжлийн шинэ боломж олгохын зэрэгцээ нийгмийн бусад сөрөг үзэгдлүүдийг ч дагуулсаар тэдгээрийн нэг нь “Цахим” гэмт хэрэг буюу “Цахим гэмт халдлага” юм.

Энэхүү гэмт хэргийн талаар хэд хэдэн тодорхойлолт байдаг боловч /компьютер болон цахим сүлжээ ашиглаж бусдын эд хөрөнгө, алдар нэр, хувийн нууц, аюулгүй байдал, өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд нь хууль бусаар халдаж буй өөр өөр төрлийн гэмт хэргийн нийлбэр/ хэмээн хамгийн энгийнээр тайлбарлаж болно.

Энэхүү гэмт хэргийг үйлдэгчдийн тоо жил бүр нэмэгдэж, арга хэлбэр нь илүү боловсронгуй, залуус тэр тусмаа бага насны этгээдүүд холбогдох сонирхол татахаар байна. Иймд цахим гэмт хэрэг гэж юу болох, түүний онцлог шинж чанар, гэмт этгээдүүдийн үйл ажиллагааны талаар ойлголт, мэдээлэлтэй болсноор хохирогч болохоос урьдчилан сэргийлэх боломжтой.

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан судалгаагаар Монгол Улсад 2016 оны байдлаар давхардсан тоогоор 2.512.100 интернэт хэрэглэгч байгаагаас 30 сүлжээний хэрэглэгч 90.97 хувийг эзэлж, нийт хэрэглэгчийн хамрах хүрээ 86.7 хувь нь Улаанбаатар хотод, 10.3 хувь нь аймгуудад, 2.9 хувь нь сумдад, интернэт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 59 аж ахуй нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Монгол улсад 1990 он гарснаар орж ирсэн шинэ төрлийн гэмт хэргүүдийн нэг бөгөөд энэ нь Дэлхийн улс орнуудаас жишээ нь: “АНУ-д цахим гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгддэг бөгөөд Холбооны мөрдөх товчоо жилд 300 мянга орчим, өдөрт 900 гаруй цахим гэмт хэрэгтэй холбоотой өргөдөл, гомдол хүлээн авдаг байна. Хэдийгээр цахим гэмт хэргийн объект өргөн хүрээг хамардаг ч гэмт этгээдүүд богино хугацаанд өндөр ашиг олох боломжтой хэмээн үзэж хувь хүн болон байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг цахим халдлагын бай болгох сонирхолтой байдаг”

Үүнээс гадна “Facebook”, “Twitter” зэрэг нийгмийн сүлжээг ашиглан цахим гэмт хэрэг үйлдэгчид жилд тутам их хэмжээний хохирол бусдад учруулдаг бөгөөд хохирогчдын тоо жил бүр нэмэгдсээр байна. Энэ төрлийн гэмт хэргийн дотроос нийгмийн сүлжээ хэрэглэгчдийн нэвтрэх нэр, нууц үг, дансны болон

зээлийн картын мэдээлэл зэрэг хувийн мэдээллийг хулгайлах, бусдад зарж борлуулах явдал хамгийн түгээмэл хувийг эзэлдэг.

Цахим гэмт хэргийн хамгийн түгээмэл хэлбэрүүдэд “фишинг” буюу интэрнетээр залилан үйлдэх, “сошиал инженерчлэл” буюу хувь хүний сэтгэл зүйн онцлогийг харгалзан сэдэл /мөнгө хожих, тэтгэлэг авах зэрэг/ өгч, итгэл төрүүлэх замаар мэдээлэл цуглуулах, нууцад нэвтрэх болон компьютерийн сүлжээнд төрөл бүрийн вирус, хортой код тараах зэрэг аргууд багтдаг.

АНУ-ийн “Accenture securtiy” байгууллагын 2019 оны “Кибер гэмт хэргээс учирсан хохирол”-ийн талаарх тайланд дурдсанаар “фишинг” болон “сошиал инженеринг” хэлбэрийн халдлагад өртсөн байгууллагын тоо 2018 онтой харьцуулахад 16 хувиар өсч, нийт цахим халдлагад өртсөн байгууллагын 85 хувийг эзэлж, Харин хортой код ашиглаж үйлдсэн халдлагын улмаас 2018 онд 2.6 сая ам.долларын хохирол учирсан нь өмнөх оноос 11 хувиар өссөн үзүүлэлттэй байна гэсэн мэдээлэл хийж байжээ.

Харин австралийн их сургуулийн судалгаагаар, биткоин нь цахим гэмт хэрэгтнүүдийн төлбөрийн хамгийн таатай хэрэгсэл бөгөөд жилд 76 орчим тэрбум ам.долларын биткоин гүйлгээ хийгдэж байгаа нь АНУ, Европын Холбооны орнууд дахь хар тамхи, мансууруулах бодисын хууль бус худалдаанаас олох ашиг орлоготой тэнцэж байна хэмээн дүгнэжээ. АНУ-ийн цахим аюулгүй байдлыг хангах байгууллага 2021 он гэхэд криптовалют ашиглан үйлдэгдэх цахим гэмт хэргийн тоо мэдэгдэхүйц хэмжээгээр өсөх бөгөөд нийт криптовалютын гүйлгээний 70 орчим хувь нь гэмт хэрэгтэй холбоотой байна хэмээн тооцоолжээ

Иймээс улс орнууд цахим гэмт хэрэгтэй тэмцэхэд анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд манай улсад энэ төрлийн гэмт хэрэг нийлээд ажиглагдах, цаашлаад өсөх хандлага харагдаж байгаа юм. Монгол улсын эрүүгийн хуульд энэ төрлийн гэмт хэргийн үйлдэл, эс үйлдэхгүйг нарийвчлан тусгах нь цаашид энэ төрлийн гэмт хэргийг зөв ангилан оногдуулах зүйл заалтад чухал ач холбогдолтой юм.

Үндсэн хэсэг

Манай улсын хувьд цаг тутамд өсөн нэмэгдэж буй компьютер, ухаалаг утасны хэрэглээг дагаад цахим гэмт хэргийн тоо жил бүр нэмэгдэж байгаа билээ. Цахим гэмт хэргийн талаар төдийлөн хангалттай мэдээлэл байхгүй ухаалаг үйлдэлд суурилсан ажлыг хөнгөвчилсөн гэх ойлголтууд нь нийтлэг яригдах боловч түүнээс үүсэх үр дагавар аюулгүй байдал одоо цагт хурцаар тавигдаж байгаа зүйл юм.

Монгол улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн

- 13.10 дугаар зүйл. Хувь хүний нууцад халдах хэсэгт “Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан бол...” Энэ

гэмт хэргийг харилцаа холбоо, цахим хэрэгсэл ашиглаж үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй.

- 16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах “Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол ..” Энэ гэмт хэргийг цахим сүлжээ ашиглаж үйлдсэн.

- 17.3 дугаар зүйл. Залилах “Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол ..”

- 26.1 дүгээр зүйл. Цахим мэдээлэлд хууль бусаар халдах “Цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж компьютерийн өгөгдөл, системд нэвтэрсэн, танилцсан бол...”

мөн “Цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж мэдээллийг устгасан, гэмтээсэн, өөрчилсөн, засварласан, хуулбарлаж авсан, мэдээлэл нэмж оруулсан, программ хангамж, сүлжээг ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан; компьютерийн өгөгдлийг нуусан, хандалтад хязгаарлалт тогтоосон, компьютерийн системд санаатайгаар хууль бусаар мэдээлэл дамжуулсан, үйл ажиллагааг хязгаарласан; мэдээлэл хадгалагдаж байгаа төхөөрөмжийг устгасан, гэмтээсний улмаас бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол.....”

- 26.2 дугаар зүйл. Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах “Цахим төхөөрөмж, мэдээллийн хамгаалалттай сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай программ, техник хэрэгслийг бэлтгэсэн, борлуулсан бол...”

- 26.3 дугаар зүйл. Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах” Цахим төхөөрөмжид хадгалагдаж байгаа мэдээллийг зөвшөөрөлгүйгээр устгах, гэмтээх, өөрчлөх, хуулбарлах, мэдээлэл олж авах, программ хангамж, мэдээлэл хадгалагдаж байгаа төхөөрөмж, сүлжээг ашиглах боломжгүй болгох, хэвийн үйл ажиллагааг алдагдуулах зориулалттай хор хөнөөлт программ хангамжийг тусгайлан зохиосон, зориудаар ашигласан, санаатай тараасан бол ..”

Гэх зүйлчлэлээр тусгасан байдаг нь гэмт хэргийн өнөөгийн нөхцөлд төдийлөн ханалттай хэмжээнд шалгагдахгүй гэмт хэргийн шинжийг агуулсан зарим үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй өнгөрөх зэрэг цахим гэмт хэргийн нийгэмд учруулж буй хор хөнөөлийг бүрэн тодорхойлох зөв зүйлчлэл хийхэд хүндрэл учруулж байна.


Монгол улсын цагдаагийн ерөнхий газрын нийт гэмт хэргийн талаарх мэдээллээс үзэхэд

Хүснэгт №1¹¹⁸

¹¹⁸ Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээ 2020 он

№	Цахим мэдэллэлийн аюулгүй байдлын эсрэг				
Эрүүгийн хуулийн 26.1. - 26.3.	2017	2018 он	2019 он	2020 он	2021 он Эхний 3-р сарын байдлаар
	43	42	47	119	134

График №1



Энэхүү хүснэгтээс харахад 2017 оноос хойш монгол улсад цахим гэмт хэрэг буюу цахим мэдэллэлийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралтын тоон үзүүлэлт өссөн харагдаж байна. Энд зөвхөн гэмт хэргийн талаарх санал гомдол хүлээн авч хэрэг нээсэн талаарх мэдээлэл байгаа бөгөөд иргэдээс ирсэн гомдол санал нь сүүлийн жилүүдэд 500-аас дээш бүртгэгдэж байгаа гэж мэдээлсэн байдаг.

Баримт1: Улаанбаатар хотод оршин суух эрхэлсэн тодорхой ажилгүй М, Б нар нь цахим орчинд бусдын зургийг зөвшөөрөлгүй байршуулан хуурамч фэйсбүүк хаяг үүсгэж иргэдтэй танилцан дотносох замаар хувийн мэдээлэл видео бичлэгийг цуглуулсан байна.

Эдгээр залуус хувь хүний мэдээллийг олон нийт, найз нөхдөд нь тараана хэмээн сүрдүүлж зургаан иргэнээс их хэмжээний мөнгө авсан гэмт үйлдлийг бүлэглэн үйлдэж байсныг таслан зогсоож, Чингэлтэй дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтэст эрүүгийн хэрэг үүсгэн тус тус шалгагдаж байна¹¹⁹.

Баримт2: Facebook орчинд садар самууныг сурталчилсан группүүдэд эмэгтэй хүний зураг ашигласан хуурамч хаягаар “Video call” хийнэ, “Video чат” хийнэ гэх мэт утгатай зар байршуулж, урьдчилгаа мөнгө авах замаар бусдыг залилан мэхэлдэг, мөн хохирогч өөрийн жинхэнэ хаягаар харилцсан тохиолдолд бичсэн чат мэдээлэл болон илгээсэн зураг зэргийг гэр бүл, найз нөхөд рүү тараана гэх мэтээр мөнгө нэхэн заналхийлэх үйлдэл хийдэг тодорхой эрхэлсэн ажилгүй

¹¹⁹ Цахим гэмт хэрэгтэй тэмцэх алба 2016 он /<https://police.gov.mn/a/2287/>

“Д” гэгчийг Эрүүгийн цагдаагийн албаны Cyber гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс илрүүлэн шалгаж байна.

Уг этгээд нь урьдчилгаа хэлбэрээр хохирогчоос 10.000 – 40.000 төгрөг авч видео дуудлага хийнэ гэж залилдаг, мөн харилцах явцдаа олж авсан мэдээллээ барьцаалж мөнгө нэхдэг, мөнгө өгөхгүй бол гэр бүл, найз нөхөд рүү нь мэдээллийг нь олон нийтийн сүлжээгээр тараана гэх зэргээр заналхийлж 100.000–300.000 төгрөгийг бусдаас авч байсан талаараа мэдүүлсэн.

Монгол улсын цагдаагийн ерөнхий газар нийт гэмт хэргийн судалгаа нь эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1-26.3 хүрээнд авагдсан нь цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт холбогдуулан завдсан учир энэ төрлийн гэмт хэргийн бүрэн шинжийг илэрхийлж чадахгүй байна. Цахим гэмт хэрэгт өөр төрлийн гэмт хэрэг давхар зүйлчлэлийн шинжийг агуулж байгаа тул гэмт хэрэг зүй тогтлыг харгалзах нь чухал зүйл болоод байна.

Хүснэгт №2 ¹²⁰ Энэ төрлийн гэмт хэргийн шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийг шүүхийн шийдвэрээс түүвэр хийн харуулбал:

№	Шүүхийн нэр	Огноо	Дугаар	Шүүгч	Зүйл хэсэг
1	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018-11-29	914	Ц.Д	26.1.1.,
2	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018-08-28	735	Б.Д	17.6.1., 26.1.2.,
3	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018-05-01	156	Д.А	26.1.2.,
4	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018-01-29	023	П.Д	26.1.1.,
5	Сонгино хайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-12-19	1354	Б.Б	17.3.1., 26.1.1.,
6	Сонгино хайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-08-30	812	Б.Б	17.1.1., 26.1.1.,

¹²⁰ Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан 2018-2021 онд шийдэгдсэн хэргүүд <https://shuukh.mn/cases>

7	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-12-02	1813	Т.Ш	26.1.2.,
8	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-08-08	1255	Д.М	26.1.2.,
9	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-05-27	852	Н.Б	26.1.2.,
10	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-05-21	815	Н.Б	26.1.2.,
11	Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-07-22	731	Д.М	26.1.2.,
12	Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-03-29	299	Б.Д	18.6.1., 26.1.1.,
13	Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-01-03	34	Д.Р	26.1.2.,
14	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019-01-02	20	Ё.Ц	26.1.2.,
15	<u>Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх</u>	<u>2020-08-18</u>	<u>747</u>	<u>Ц.М</u>	<u>26.1.2.,</u>
16	<u>Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх</u>	<u>2020-08-05</u>	<u>2020/Ц ШТ/245</u>	<u>Г.Н</u>	<u>26.1.2.,</u>
17	<u>Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх</u>	<u>2020-06-04</u>	<u>537</u>	<u>Б.М</u>	<u>17.3.1.,</u> <u>26.1.1.,</u>
18	<u>Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх</u>	<u>2020-06-03</u>	<u>1028</u>	<u>Ц.А</u>	<u>26.1.2.,</u>
19	<u>Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх</u>	<u>2020-06-03</u>	<u>00188</u>	<u>М.Э</u>	<u>26.1.1.,</u>

20	<u>Чингэлтэй дүүргийн</u> <u>Эрүүгийн хэргийн анхан</u> <u>шатны шүүх</u>	<u>2020-05-27</u>	<u>406</u>	<u>Д.Р</u>	<u>26.1.2.,</u>
21	<u>Хан-Уул дүүргийн</u> <u>Эрүүгийн хэргийн анхан</u> <u>шатны шүүх</u>	<u>2020-04-24</u>	<u>254</u>	<u>И.Г</u>	<u>26.1.2.,</u>
22	<u>Хан-Уул дүүргийн</u> <u>Эрүүгийн хэргийн анхан</u> <u>шатны шүүх</u>	<u>2020-04-24</u>	<u>256</u>	<u>Н.М</u>	<u>26.1.2.,</u>
23	<u>Баянгол дүүргийн</u> <u>Эрүүгийн хэргийн анхан</u> <u>шатны шүүх</u>	<u>2020-04-10</u>	<u>351</u>	<u>А.А</u>	<u>17.3.1.,</u> <u>26.1.2.,</u>
24	<u>Баянгол дүүргийн</u> <u>Эрүүгийн хэргийн анхан</u> <u>шатны шүүх</u>	<u>2020-03-30</u>	<u>305</u>	<u>Ц.М</u>	<u>26.1.2.,</u>
25	<u>Чингэлтэй дүүргийн</u> <u>Эрүүгийн хэргийн анхан</u> <u>шатны шүүх</u>	<u>2020-01-28</u>	<u>94</u>	<u>С.Б</u>	<u>26.1.2.,</u>
26	<u>Хөвсгөл аймаг дахь сум</u> <u>дундын эрүүгийн</u> <u>хэргийн анхан шатны</u> <u>шүүх</u>	<u>2021-01-25</u>	<u>2021/Ш</u> <u>ЦТ/35</u>	<u>М.Э</u>	<u>17.3.1.,</u> <u>26.1.1.,</u>
27	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2021-03-09	2021/Д ШМ/236	Н.Б	26.2.1.,
28	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2020-07-07	878	С.С	23.2.1., 26.1.2.,
29	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2020-06-04	730	Ш.Б	26.1.2.,
30	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2020-05-14	618	Н.Б	26.2.1.,
31	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2020-04-02	580		26.1.2.,
32	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2020-01-30	151		26.1.2.,

33	Булган аймгийн эрүү, иргэний давж заалдах шатны шүүх	2020-04-02	16		26.2.1.,
----	--	------------	----	--	----------

График 2



2017 онд Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэсэн байхгүй. Харин он өнгөрөх тусам, сүүлийн жилүүдэд илүү нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. 2021 оны үзүүлэлтийн хувьд 2021 оны эхний 3 сарын хугацаанд шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг тул цаашид нэмэгдэх хандлагыг тодорхойлж болохоор байна.¹²¹

Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан судалгаагаар 2017 оны арван хоёрдугаар сарын 31-ний өдрийн байдлаар манай улсад 2.910.778 интэрнет хэрэглэгч байгаагаас Мобил дата, буюу ухаалаг гар утсаар интэрнет хэрэглэгч 90.21 хувийг эзэлж байна. Өрх гэр болгон интэрнеттэй, хүн болгон ухаалаг гар утас хэрэглэгч, интэрнет хэрэглэгч болсон гэхэд хилсдэхгүй. Гэвч энэ өсөлт хөгжлөө дагаад цахим орчинд хуурамч нэр хаягаар өсвөр насны хүүхдүүдийг буруу, хорт зуршил уруу татах, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, дарамтлах, залилах, хууран мэхлэх гэмт хэргүүд ихээр гарах болсон. Эдгээр хүчин зүйлсийг авч үзвэл эцэг, эхчүүд, асран хамгаалагч нарын хяналт сул, анхаарал болгоомж, мэдээлэлгүй гээс болоод энэ төрлийн гэмт үйлдлүүд гарсаар байгааг цагдаагийн байгууллагаас сануулж, олон талын урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлуудыг зохион байгуулсан бөгөөд Цагдаагийн Ерөнхий Газраас зөвлөмж болгож кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийтлэг 10 аргыг танилцуулсан.

Иргэд, олон нийтэд гэр бүлээ цахим гэмт хэрэгт өртөхөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ямар алхмуудыг хийх ёстой вэ. Үүнд:

- Компьютерын системээ шинэчилж байх
- Системийн тохиргоогоо хамгаалах

¹²¹ Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан 2018-2021 онд шийдэгдсэн хэргүүд <https://shuukh.mn/cases>

- Нэвтрэх үг буюу нууц үгээ сайжруулж, хамгаалах
- “Галт хана”-аа асаалттай байлгах
- Вирусны эсрэг программ суулгах буюу түүнийгээ шинэчилж байх
- Хувийн мэдээллээ хамгаалах
- Веб сайтын нууцлалын бодлогыг хэвлэн авч, анхааралтай унших
- Санхүүгийн мэдээлэл, дансны хуулгаа тогтмол хянах
- “Үнэгүй зүйл зөвхөн хавханд л байдаг” буюу танд маш их аз тохиолдоход эргэлзэн нягтлан шалгаж байх
- Компьютероо унтраах¹²²

Гэх арга зааварчилгааг гарган танилцуулж байсан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний нэг хэлбэр болгон танилцуулж байгаа боловч иргэдэд төдийлөн хүрч хүрч чадахгүй сайтад мэдээлэл хэлбэрээр байршуулсан байдал хангалттай бус харагдаж байна.

Олон улсын хэмжээнд цахим халдлагын талаар дараах хэлбэрүүд их түгээмэл шинжтэй болсон байна. Үүнд: Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг таны цахим аюулгүй байдлыг хорлох түгээмэл аргуудын хэсгээс

1. Хэт их хувийн мэдээлэл өгөх. /Та өөрийгөө эсвэл танай компанийг төлөөлж байгаа эсэхээс үл хамааран төрсөн он сар өдөр, сургуульд сурч байсан газар, гэр бүлийн гишүүдийн нэр, зураг зэргийг хуваалцахаас зайлсхий. Эдгээр нь таних хулгайч нарын ихэнх нь таны дансанд нэвтрэх, эсвэл хувийн мэдээллээ ашиглан зээлийн карт авахад хангалттай юм.
2. Хортой программ. Ихэнх хортой программууд имэйл, татаж авах холбоосууд дотроо нуугддаг бол богиносгосон URL-уудаар дамжуулан олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тарааж, эсвэл нийгмийн мэдээллийн зар дотор нуугдаж болно. Хэрэглэгч холбоос дээр дарж, Instagram-ийн ердийн профайлыг үзэх гэж байгаа бөгөөд дараа нь өөрсдийгөө кибер халдлагад өртөх боломжтой гэж бодож байна.
3. Муурын загас. Гэсэн хэдий ч онлайн болзооны хамгийн нийтлэг бэрхшээлүүдийн нэг бол загас барих явдал бөгөөд таны хамтрагч таних тэмдгээ хуурамчаар үйлддэг.
4. Нүүр хуудас. Та амралтаараа баяртай байх болно, гэхдээ та үндсэндээ танихгүй хүмүүст гэртээ байхгүй цагийг яг хэлж байгаа нь тэдэнд үнэ цэнэтэй зүйлийг нэвтэрч, хулгайлахад хангалттай цаг хугацаа өгдөг.
5. Баталгаагүй гар утасны төхөөрөмжүүд. Өөр хэн нэгэн таны хамгийн хувийн мэдээлэл, харилцан ярианд шууд нэвтрэх боломжтой болох юм. Та ядаж утсаа хүчтэй нууц үгээр хамгаалаарай.¹²³

Улс орнууд картын дугаартаа 4-н оронтой 80% болон 6-н оронтой 20% хэлбэрээр оруулдаг энэ нь “All credit card PIN numbers in the World leaked” Дэлхийн

¹²² Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж нийтлэл 2018 он <http://eagle.mn/r/49343>

¹²³ <https://www.ccsinet.com/blog/social-media-cybersecurity/?fbclid=IwAR1evXVbnziQynM01VwoG0KUNUVwCw3uxZfNbZvNu4Gn0at82UL9SSPRW5w>

бүх зээлийн картын ПИН дугаарууд ил боллоо гэх мэдээлэл дээр суурилагддаг пин кодийг хэрхэн олох таамаглах талаар pin analysis –ийн судалгаанаас харж болох юм.

- Хамгийн алдартай нууц үг бол 1234 3.4 сая нууц үгийн бараг 11% нь 1234 байна !!!
- Ашиглагдаж буй хамгийн алдартай 4 оронтой PIN код нь 1111 бөгөөд 6% -иас дээш нууц үг ашигладаг.
- Гуравдугаарт 0000 бараг 2% -тай байна.
- Шилдэг 20 нууц үгийн хүснэгтийг доор харуулав. Эдгээр 20 хослолыг туршиж үзэхэд бүх нууц үгсийн 26.83% -ийг таамаглаж болох юм!

(Статистикийн хувьд 10,000 боломжит хослолтой бол нууц үгийг санамсаргүй байдлаар тараасан тохиолдолд эдгээр хорин нууц үгийг нийт дүнгийн 26.83% -ийг биш зөвхөн дөнгөж 0.2% -ийг эзэлнэ гэж найдаж байна)

1122 ба 1313 гэх мэт загварууд жагсаалтад дээгүүр гарч ирдэг.

2001 он #19-т гарч ирэв. 1984 он 26-р байрнаас холгүй араас нь дагаж яваа бөгөөд Жеймс Бондын фэнүүд 237-р байрын хооронд 0007 байгааг олж мэдэхийг сонирхож магадгүй юм (өөр хувилбар 0070 # 28-ийн ард нэг их удаагүй байна)¹²⁴.

Хүснэгт №3

PIN	Freq	%	PIN	Freq	%
#1	1234	10.713%	#11	9999	0.451%
#2	1111	6.016%	#12	3333	0.419%
#3	0000	1.881%	#13	5555	0.395%
#4	1212	1.197%	#14	6666	0.391%
#5	7777	0.745%	#15	1122	0.366%
#6	1004	0.616%	#16	1313	0.304%
#7	2000	0.613%	#17	8888	0.303%
#8	4444	0.526%	#18	4321	0.293%
#9	2222	0.516%	#19	2001	0.290%
#10	6969	0.512%	#20	1010	0.285%

Хакерууд нууц үгийг таамаглаж олдог бөгөөд тэд гэрийн тэжээвэр амьтадын нэрийг, хүүхдийнх нь төрсөн өдөр, эсвэл тэмдэглэлт ойн баярын өдөр зэргийг нь олон нийтийн сүлжээ болон нээлттэй бусад интернэт эх сурвалжаас олж мэддэг байна. Энд иргэд хамгийн ойрын эсвэл хамгийн дурсамжит зүйлдээ тулгуурлан нууц үгийг оруулдаг нь алдаа болдог байна.

Мөн Фишинг имэйлүүд нь танай банк, таны ажил олгогч эсвэл найз гэх мэт найдвартай эх сурвалжаас ирсэн мэт харагддаг, гэхдээ үнэхээр хакерууд болон

¹²⁴ Nicole Dahya, Information Technology Services, 2019 https://now.uiowa.edu/2019/09/avoid-these-10-common-phishing-emails?fbclid=IwAR0bOsWc2QthtFDfNgH0ag7CL6p0BmaCIJY2jaTjmomNd_iBkiikgbJg6XE

хуурамч уран бүтээлчдээс ирдэг. Имэйл нь таныг компьютерт хортой программ татаж авах эсвэл нууц үг, дансны дугаар эсвэл бусад хувийн мэдээллийг илчлэх линк дээр дарж хуурахыг оролддог¹²⁵.

Иймд цахим халдлага ба түүнээс урьдчилан сэргийлэх арга өнөөгийн бидний амьдралд зайлшгүй зүйлийн нэг ялангуяа монгол улсын хувьд энэ төрлийн гэмт хэрэг жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь сэтгэл түгшээсэн зүйлсийн нэг юм.

Дүгнэлт, санал:

Цахим гэмт халдлагын үндсэн дараах төрлүүд голлох байр эзэлж байгаа бөгөөд эдгээр шинжүүд монгол улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд ихсэх хандлагатай байгаа нь харамсалтай. Жишээ нь:

- Танаас хувийн мэдээлэл хүссэн сэжиг бүхий мэйл, хуудас нь хэрэгтний өгөөш, гэмт үйлдлийн халхавч байдаг бөгөөд таны мэдээллийг ашиглан залилан мэхлэх шинж.
- Фэйсбүүктээ гар утас, ажил болон гэрийн хаяг зэргээ бичихгүй байх, Ямар нэгэн зүйл бичихдээ "Location" буюу байршлаа бусдад мэдэгдэхгүй байх энэ нь гэмт этгээдэд өөрийн орон байр эзэнгүй байгааг мэдээлж байгаа хэлбэр болдог.
- Чатаар найз орж ирээд сэжигтэй яриа өрнүүлбэл, мөн ямар нэгэн тусламж хүсэхдээ мөнгөн хэлбэрээр яаралтай тусламж хүссэн хүн рүү шууд утсаар холбогдон баталгаажуулах.
- Эх үүсвэрийг нь мэдэхгүй болон бусад сугалаа шалгах холбоос дээр дарахгүй байх. Энэ нь сэжиг бүхий дүрс бичлэг, зураг нь үнэндээ таны хувийн мэдээллийг хулгайлах зорилготой хортой программ байдаг. Спам, хуурамч мэйлд хуурагдсанаар та хувийн чухал мэдээллээ кибер гэмт хэрэгтэнд алдах нөхцөл болдог.¹²⁶

Эдгээр үндсэн аргууд нийтлэг хэрэглэгдэж бусдыг хохироох үйлдэл гарсаар байна. Цахим гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх арга замыг нарийн тодорхойлох нь энэ төрлийн гэмт хэрэг хэрхэн гардаг Монгол улсын эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар илүү нарийн гэмт хэргийн шинжийг тусган хуульчлан оруулах нь зайлшгүй тулгамдсан асуудлын нэг болж байна. Үүнд урьдчилан сэргийлэх дараах хэлбэрүүдийг хувь хүн болгон хэрэглэж сурах үүнд:

- 2 factor authentication буюу тухай бүр солигдох шинжтэй давхар код оруулж хэвшүүлэх
- Нууц код ашиглахдаа өөрийн том жижиг үсэг, тоо, тусгай тэмдэг орсон байх мөн олон төрийн нууц кодыг нэгэн ижил хэлбэрээр оруулахгүй байх нь маш чухал

¹²⁵ Nicole Dahya, Information Technology Services, 2019 https://now.uiowa.edu/2019/09/avoid-these-10-common-phishing-emails?fbclid=IwAR0bOsWc2QthtFDfNgH0ag7CL6p0BmaCIJY2jaTjmomNd_iBkiikgbJg6XE

¹²⁶ Л.Ганбаатар, мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн асуудал: цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь <http://galbaatar.blogspot.com/> 2018 он

- Хэд хэдэн хаяг үүсгэж түүнийг эргэх холбоо бүхий ашиглах, нэг майл хаягт бусад хаяг болон мэдээлэл авах болгон холбохгүй байх.
- Танд ирж байгаа мэйл нь бодит уу мэйл хаягтай холбоотой, нууц үг солих болон шинээр авах гэсэн мэйлыг заавал шалгах

Одоо мөрдөгдөж байгаа монгол улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн 26-р бүлэг “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” нэмэлтээр дээрх нөхцөлөөр халдаж байгааг гэмт хэргийн зүйлчлэл болгон ял ногдуулахаар хуульчлан оруулах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хийгээд энэ төрлийн гэмт хэрэг дахин үйлдэгдэхээс сэргийлэх гол хүчин зүйл болно. Жишээ нь: “Хуурамч мэйл хаягаар бусад хүний нууц үгийг олж аван өөрчилсний улмаас харилцах данснаас нь мөнгө хулгайлсан, завшсан, бусад найз нөхдөөс нь мөнгөн тусламж үзүүлэхийг шаардсан, бусадтай харилцдаг нэр төрийг буруугаар ашиглан хохирол учруулсан, бусад буруу ойлголт төрүүлэн нэр төрд халдсан бол..” гэх нарийн зохицуулалтаар зүйлчлэл оруулах нь зүйтэй байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

Монгол эх сурвалж

1. Ч.Батзориг., “Цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалт /харьцуулсан судалгаа/” 2018 он,
2. Г. Бямбажаргал, “Цахим гэмт хэргийн талаарх онцлох баримтууд” 2020 он нийтлэл
3. Л.Ганбаатар, “Мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн асуудал: цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” 2018 он эрдэм шинжилгээний өгүүлэл
4. Д.Сумъяацэрэн, “Монгол Улс дахь кибер гэмт хэргийн нөхцөл байдал, үйлдлийн арга, урьдчилан сэргийлэх асуудал”, 2017 онд хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл.

Эрх зүйн эх сурвалж

1. Монгол улсын үндсэн хууль 1992 он
 2. Монгол улсын эрүүгийн хууль 2015 он
- Бусад эх сурвалж
1. Тагнуулын ерөнхий газрын цахим мэдээллийн сан: сонирхуулах булан
 2. Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан 2018-2021 онд шийдэгдсэн хэргүүд <https://shuukh.mn/cases>
 3. Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээ 2020 он
 4. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх алба 2016 он <https://police.gov.mn/a/2287>
 5. Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж нийтлэл 2018 он <http://eagle.mn/r/49343>

Гадаад цахим эх сурвалж

1. <https://gia.gov.mn/49/item/643?fbclid=IwAR0ZHxKUWskShqpJGK9diBw1V0eAwqhrDL6Bnh4ucrBylMcuDfuka-ilQg8>

2. <https://www.ccsinet.com/blog/social-media-cybersecurity/?fbclid=IwAR1evXVbnziQynM01VwoG0KUNUVwCw3uxZfNbZvNu4Gn0at82UL9SSPRW5w>
3. https://www.datagenetics.com/blog/september32012/?fbclid=IwAR03KjzN8-IlekRMMD_44skY1KY0xlq3AKv0z7ZA3ASkMk0D_kmZVwg9dQU
4. Megan Kaczanowski 2020 /#INFORMATION SECURITY
https://www.freecodecamp.org/news/an-intro-to-password-cracking/?fbclid=IwAR1sbA0FLerhWnZqxWGt8DN_0K3z1H6CudYWxuUeNCoSmoF-v1oi3gHN
5. Nicole Dahya, Information Technology Services, 2019
https://now.uiowa.edu/2019/09/avoid-these-10-common-phishing-emails?fbclid=IwAR0bOsWc2QthtFDFNgH0ag7CL6p0BmaCIJY2jaTjmomNd_iBkiikgbJg6XE

---o0o---